**ХЭНТИЙ АЙМАГ**
**ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 11 өдөр Дугаар А/132 Өмнөдэлгэр сум

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран
өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, "Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд, "Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай" хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн эрх шилжүүлэх гэрээ, хэлцлийг харгалзан газрыг хавсралтад дурдсан 1 иргэнд үнэ төлбөргүй шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2. Гэр бүлийн нэг гишүүний өмчилж авсан газарт энэхүү захирамжийг үндэслэн газрын кадастр хийх, газар өмчлөгчид хүлээлгэн өгөх, хилийн заагийг газар дээр нь тэмдэгжүүлэх, улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан хавсралт дахь сумын Засаг даргын захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Газраа шилжүүлсэн иргэнд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

Б.ЭРДЭНЭБААТАР

D:disk/bichig hereg/ zahiramj

сумын Засаг даргын 2024 оны
06 дугаар сарын 11-ны өдрийн
А/132 дугаар захирамжийн хавсралт

| д/д | Өмчлөх эрхээ шилжүүлэн авч байгаа иргэний | | | | Хамтран өмчлөлөөс хасуулж байгаа иргэний | | | | Өмнөх | | | | | | Хэмжээ /м2/ | Байршил |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Захирамжийн | | | | Газрын | | | |
| | Ургийн овог | Овог | Нэр | Регистрийн дугаар | Ургийн овог | Овог | Нэр | Регистрийн дугаар | Огноо | Дугаар | Хавсралтын дугаар | Холбогдох хэсгийн дугаар | Нэгж талбарын дугаар | Хэмжээ /м2/ | | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| 1 | Цоохор | Цэнд | Наранбаяр | СР80052011 | Цоохор | Наранбаяр | Мөнх-Оргил | СР08251410 | 2003 | 62 | | | 221500017 | 1015 | 1015 | М.Гаасүрэн 5-р гудамж 500 тоот |
| Дүн | | | | | | | | | | | | | | 1015 | 1015 | |